

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 07 ДУГААР ХУРАЛ**

2020 оны 02 дугаар сарын 05-ний өдрийн 09 цаг 05 минутад эхэлж, мөн өдрийн 11 цаг 30 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 2 цаг 25 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	2020 оны аймгийн алдарт уяач шалгаруулах тухай	Аймгийн алдарт уяачын болзол хангасан Жаргалант сумын уяач Тогоочын Алтангэрэл, Шагдарын Батсуурь, Батсүхийн Гантулга, Содмоогийн Ганхуяг, Уртнасангийн Пүрэв, Даваанямын Цэрэн, Зэрэг сумын уяач Галсандашын Отгонбаяр, Мөст сумын уяач Бямбацэрэнгийн Галбаатар, Цэвээн-Очирын Бямбапүрэв, Буянт сумын уяач Рагчаагийн Дэмбэрэл, Дөргөн сумын уяач Дондогдоржын Алтансүх, Дуут сумын уяач Хархарцагийн Батмөнх нар аймгийн “Алдарт уяач”-аар тус тус шалгаруулахаар дэмжиж аймгийн Засаг даргын захирамж гаргуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Даваадоржид үүрэг болгов.
2	Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төвийг Монгол Улсын төрийн шагналт, Хөдөлмөрийн баатар, мэс засалч эмч Авирмэдийн Отгондалайн нэрэмжит болгох тухай	Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төвийг Монгол Улсын төрийн шагналт, Хөдөлмөрийн баатар, мэс засалч эмч Авирмэдийн Отгондалайн нэрэмжит болгох тухай хэлэлцүүлэн дэмжиж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Даваадоржид үүрэг болгов.
3	Монгол бичгийн салбар зөвлөл байгуулах тухай	Монгол бичгийн салбар зөвлөл байгуулах тухай хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Даваадоржид үүрэг болгов.
4	Засаг даргын нөөц хөрөнгийн хүлээгдэж буй гүйцэтгэлийн	Засаг даргын нөөц хөрөнгийн хүлээгдэж буй 1.663.021 төгрөгийг

	тухай	аймгийн Засаг даргын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдалд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболд нарт тус тус үүрэг болгов.
5	2021 оны аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулах тухай	2021 оны аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулах тухай хэлэлцүүлэн дэмжиж аймгийн Засаг даргаар батлуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР